

1. Сургалтын чиглэл, үндэслэл, хэрэгцээ шаардлага, гарах үр дүн, сургалтын төрөл, дэд төрөл, хэлбэрийг тодорхой тайлбарласан албан бичиг;
2. Улсын бүртгэлийн гэрчилгээ (нотариатоор батлуулсан хуулбар);
3. Магадлан итгэмжлэлийн батламж (нотариатоор батлуулсан хуулбар, энэ нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагад хамаарна);
4. Төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлагын дагуу бэлтгэсэн байгууллагын танилцуулга, тусламж, үйлчилгээний үзүүлэлт, байгууллагын дотоод журам, сургалтын үйл ажиллагаа эрхлэх журам болон сургалтын нэгж, багшлах бүрэлдэхүүнийг баталсан шийдвэрийн хуулбар, сургалт удирдах багш нарын чадавхийн түвшинг тодорхойлсон баримт бичгүүдийн хуулбар (боловсролын түвшин, мэргэшил, мэргэжлийн зэрэг болон эмнэл зүйн сургагч багшаар бэлтгэгдсэнийг нотлох баримт бичгийн хуулбар), бусад нотлох баримт;
5. Сургалтын батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөө.

Тайлбар:

1. Төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага нь зөвшөөрөл хүсэхэд дараах баримт бичгийг бүрдүүлж, ажлын албанд ирүүлнэ.
2. Ажлын алба нь сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг /сургалтын чиглэл бүрээр/ үнэлэх аргачлалын дагуу үнэлж, нийт үнэлгээний хувь 80 ба түүнээс дээш тохиолдолд мэргэшүүлэх сургалт эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр, тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
3. Эмнэл зүйн чиглэлээр мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалт, багц цагийн богино хугацааны сургалтын зөвшөөрөл хүссэн байгууллагын хувьд сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлагын 6, 7, 9, 11, 12, 13, 15, 16-д заасан найман шаардлага нь тухайн сургалтын чиглэл тус бүрийн нийт үнэлгээний 70 хувийг эзэлнэ.
4. Дээрх найман шаардлагын аль нэг нь 69 ба түүнээс бага хувиар үнэлэгдсэн тохиолдолд эмнэл зүйн мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалт, багц цагийн богино хугацааны сургалт эрхлэх зөвшөөрлийг тухайн сургалтын чиглэлээр олгохгүй.